



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 09 сарын 21 өдөр

Дугаар A/105

Улаанбаатар хот

Г

Т

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Татварын ерөнхий хуулийн 77 дугаар зүйлийн 77.7.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Татварын албаны хүний нөөц бүрдүүлэлтийн журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Татварын албаны хүний нөөц бүрдүүлэлтийг энэхүү журмын дагуу зохион байгуулан ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Л.Нэргүй)-т, харьяа нэгж, аймаг, нийслэл, дүүргийн татварын (газар) хэлтсийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Татварын ерөнхий газрын даргын 2013 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн “Үндэсний татварын албаны Хүний нөөцийн бодлого батлах тухай” 983 тушаал, 2020 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн “Журам батлах тухай” А/97, “Журам батлах тухай” А/98 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дэд дарга (А.Энхболд)-д даалгасугай.



ДАРГА

Б.ЗАЯАБАЛ

151611840

Татварын ерөнхий газрын даргын  
2022 оны 09 дүгээр сарын 21-ний  
өдрийн *A/105* тушаалын хавсралт

ТАТВАРЫН АЛБАНЫ ХҮНИЙ НӨӨЦ  
БҮРДҮҮЛЭЛТИЙН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын ерөнхий хууль болон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд албан хаагчийг нээлттэй, шударга өрсөлдүүлэн сонгон шалгаруулж томилох, чадахуйн зарчимд сууринлан шатлан дэвшүүлэх, шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, гүйцэтгэлд суурисан чадварлаг, тогтвортой суурьшилтай хүний нөөцийг бий болгож байгууллагын хүний нөөцийн тогтвортой хөгжлийг хангахад энэхүү журмын зорилго оршино.

Хоёр. Хамрах хүрээ

Татварын албаны хүний нөөц бүрдүүлэлтийн журам нь татварын албанд ажиллаж байгаа төрийн захирагааны удирдах, гүйцэтгэх албан тушаал, төрийн үйлчилгээний албан тушаалд хамаарах албан хаагчийг томилох, чөлөөлөх, шилжүүлэх, сэлгэх, дэвшүүлэх болон татварын улсын байцаагчийн эрх олгох, хүчингүй болгох харилцааг зохицуулна.

Гурав. Нэр томьёоны тодорхойлолт

3.1. “Хөдөлмөрийн гэрээ” гэж хураагчаар томилогдсон ажилтанд татварын улсын байцаагчийн эрх олгох нэг жил хүртэл хугацаатай хөдөлмөрийн гэрээг харилцан тохиролцож байгуулах, бусад үйлчилгээний ажилтантай хугацаагүй хөдөлмөрийн гэрээ байгуулахыг ойлгоно;

3.2. “Шилжүүлэх” гэж татварын алба, нэгж хооронд татварын улсын байцаагч, хураагчийг шилжүүлэн томилохыг;

3.3. “Сэлгэх” гэж Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-д зааснаар ойлгоно.

Дөрөв. Хураагчийг томилох, чөлөөлөх

4.1. Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.39-д заасан татварын албаны ажилтан /цаашид хураагч гэх/-д дараах шаардлагыг хангасан иргэнийг сүл орон тоонд томилж, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу харилцан тохиролцож хөдөлмөрийн гэрээ байгуулна.

4.1.1. Хураагчаар ажиллах хүсэлтэй иргэн нь Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 15 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны ерөнхий шалгалт өгөх болзол, журам”-д заасны дагуу төрийн албаны нөөцөд бүртгэлтэй байх;

4.1.2. Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан нийтлэг шаардлагыг хангасан байх;

4.1.3. Татварын ерөнхий газраас баталсан албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг бүрэн хангасан байх;

4.2. Хураагчийн туршилтын хугацаанд гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлан, сар бүр харьяалах татварын албаны захиргааны асуудал хариуцсан нэгж ажлыг дүгнэх бөгөөд үүнээс 5 сараас дээш хугацаагаар “Бүрэн хангалттай”, “Хангалттай” үнэлүүлсэн, чиглүүлэх сургалтыг амжилттай төгссөн, ёс зүй, сахилга хариуцлагын зөрчилгүй ажилласан бол тусгай шалгалт зарлуулах захиалгыг Татварын ерөнхий газрын төрийн захиргааны асуудал хариуцсан нэгжид хүргүүлнэ.

4.3. Туршилтын хугацаанд ёс зүйн зөрчил гаргасан болон сарын гүйцэтгэлийн үнэлгээгээр 3 удаа хангалтгүй үнэлгээ авсан хураагчийн хөдөлмөрийн гэрээний хугацааг дуусгавар болгон албан тушаалаас чөлөөлнэ.

4.4. Татварын ерөнхий хуулийн 77 дугаар зүйлийн 77.8-д заасны дагуу аймгийн татварын хэлтсийн дарга сумын хураагчийг томилж, чөлөөлөх, хүүхэд асрах чөлөө олгох, сахилгын шийтгэл ногдуулах шийдвэрийг гаргаж Татварын ерөнхий газрын төрийн захиргааны асуудал хариуцсан нэгжид тухай бүр хүргүүлнэ.

4.5. Энэ журмын 4.4-д зааснаас бусад татварын албанд хураагчийг албан тушаалд томилох, чөлөөлөх, сахилгын шийтгэл ногдуулах шийдвэрийг Татварын ерөнхий газрын дарга бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэрлэнэ.

#### Тав. Төрийн үйлчилгээний ажилтанг томилох, чөлөөлөх

5.1. Төрийн үйлчилгээний сул ажлын байранд сонгон шалгаруулалтыг тухайн татварын албаны захиргааны асуудал хариуцсан нэгж зохион байгуулна. Сонгон шалгаруулалтыг тухайн ажлын байрны онцлог шаардлагад тохирсон байдлаар явуулна. Үүнд:

- Ажлын байрыг нээлттэй зарлах;
- Өргөдлийн материал хүлээж авах /ТАХ анкет болон бусад материал/;
- Өргөдөл гаргагчдыг эхний байдлаар шалгаруулах;
- Албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг илүү хангаж байгаа иргэнийг сонгох;

5.2. Татварын ерөнхий газрын даргын тушаалаар төрийн үйлчилгээний албан тушаалын TY-7, TY-6 зэрэглэлд хамаарах /сумын хураагчаас бусад/, харьяа татварын албаны даргын тушаалаар төрийн үйлчилгээний албан тушаалын TY-1-ээс TY-5 зэрэглэлд хамаарах албан тушаалд албан хаагчийг томилж, чөлөөлнэ.

5.3. Татварын албаны үйлчилгээний ажилтантай Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу харилцан тохиролцож хөдөлмөрийн гэрээ байгуулж, албан тушаалын тодорхойлолт болон ажил үүргийн хуваарийг хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн танилцуулна.

5.4. Төрийн үйлчилгээний албан хаагч хөдөлмөрийн дотоод журам, ёс зүйн дүрмийг чандлан баримтлах бөгөөд ажлын цаг ашиглалт, үүрэгт ажлаа хангалтгүй биелүүлэх, сахилгын зөрчил гаргасан бол хөдөлмөрийн гэрээг цуцалж, албан тушаалаас чөлөөлнө.

Зургаа. Татварын улсын байцаагчийг томилох, чөлөөлөх

6.1. Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.30-д заасан татварын улсын байцаагчийн албан тушаалын сул орон тоог дараах байдлаар нөхнө.

6.1.1. Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлд заасны дагуу Төрийн албаны тухай хууль, албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг бүрэн хангасан төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэх, сэлгэх замаар сул орон тоог нөхнө.

6.1.2. Татварын улсын байцаагчийн сул орон тоог 6.1.1-д заасны дагуу нөхөх боломжгүй бол Төрийн албаны зөвлөлийн тогтоолоор батлагдсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-д заасны дагуу тухайн татварын алба сул орон тооны захиалгаа Төрийн албаны зөвлөлийн Татварын ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөл болон аймаг дахь Салбар зөвлөлд хүргүүлж, тусгай шалгалтыг зохион байгуулж, сул орон тоог нөхнө.

6.1.3. Төрийн албаны зөвлөлийн тухайн аймаг дахь Салбар зөвлөлийн нэр дэвшүүлсэн тогтоолыг Татварын ерөнхий газрын төрийн захиргааны асуудал хариуцсан нэгжид хүргүүлж, томилох шийдвэрийг гаргана.

6.2. Төрийн албаны зөвлөлийн тогтоолоор батлагдсан “Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам”-ыг баримтлан татварын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалын шаардлагыг хамгийн сайн хангасан төрийн жинхэнэ албан хаагчийг чадахуйн зарчимд үндэслэн шатлан дэвшүүлэх сонгон шалгаруулалтыг Татварын ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөл зохион байгуулна.

6.3. Төрийн албаны зөвлөлийн батлагдсан “Төрийн албан тушаалд туршилтын хугацаа хэрэглэх болзол, журам”-ыг баримтлан төрийн албанд анх томилогдсон татварын улсын байцаагчид туршилтын хугацааг дараах байдлаар хэрэглэнэ.

6.3.1. Сонгон шалгаруулалтаар нэр дэвшсэн хураагчийг чиглүүлэх сургалтад хамрагдан амжилттай төгссөн /серификаттай/ бол 6 сарын туршилтын хугацаагаар томилон Татварын ерөнхий газрын даргын тушаалаар татварын улсын байцаагчийн эрх олгоно.

6.3.2. Чиглүүлэх сургалтад хамрагдаагүй болон амжилтгүй төгссөн хураагчийг 6 сарын туршилтын хугацаагаар татварын улсын байцаагчийн албан тушаалд томилж, чиглүүлэх сургалтад хамруулах бөгөөд амжилттай төгссөн тохиолдолд татварын улсын байцаагчийн эрх олгоно.

6.3.3. Татварын албанд анх томилогдохоор нэр дэвшсэн иргэнийг 12 сарын туршилтын хугацаагаар томилж, туршилтын хугацаанд гүйцэтгэлийн

төлөвлөөг батлан, сар бүр дүгнэх бөгөөд үүнээс 5 сараас дээш хугацаагаар “Бүрэн хангалттай” үнэлүүлсэн, чиглүүлэх сургалтыг амжилттай төгссөн, ёс зүй, сахилга хариуцлагын зөрчил гаргаагүй бол татварын улсын байцаагчийн эрх олгоно.

6.3.4. Туршилтын хугацаанд сарын гүйцэтгэлийн үнэлгээгээр З удаа “Хангалтгүй” үнэлгээ авсан, ёс зүй, сахилгын зөрчил гаргасан бол албан тушаалаас чөлөөлнө.

6.4. Туршилтын хугацаанд албан хаагч албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргээ хангалттай гүйцэтгэж сарын ажлын гүйцэтгэлээр 5 буюу түүнээс дээш “Бүрэн хангалттай”, “Хангалттай” үнэлгээ авсан, ёс зүй, сахилгын зөрчил гараагүй талаар харьялах татварын албанаас хүсэлт ирүүлсэн бол туршилтын хугацааг дуусгавар болгож, тангараг өргүүлэх ажлыг төрийн захирагааны асуудал хариуцсан нэгж зохион байгуулна.

Долоо. Татварын албаны албан хаагчийг шатлан дэвшүүлэх,  
шилжүүлэх, сэлгэн ажиллуулах

7.1. Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан тусгай шаардлагыг бүрэн хангахаас гадна дараах шаардлагыг хангасан албан хаагчийг албан тушаалд шилжүүлэн, сэлгэн ажиллуулж болно.

7.1.1. Жижиг, бичил болон хувь хүний асуудал хариуцсан нэгжид 3-аас доошгүй жил татварын улсын байцаагчаар тогтвортой сууршилтай ажилласан байх;

7.1.2. Аймаг, дүүргийн татварын хэлтсийн хяналт шалгалтын нэгжид 7.1.1-т заасан нэгжид ажилласан, ёс зүй, сахилгын зөрчилгүй татварын улсын байцаагчийн эрхтэй албан хаагчийг шилжүүлэн томилно.

7.1.3. Жижиг, бичил болон хувь хүний асуудал хариуцсан нэгжид 3-аас доошгүй жил ажилласан татварын улсын байцаагчийг дунд, том татвар төлөгчийн асуудал хариуцсан нэгжид шатлан дэвшүүлж томилно.

7.1.4. Аймаг, дүүргийн татварын хяналт шалгалтын нэгжид 3-аас доошгүй жил үр бүтээлтэй ажилласан албан хаагчийг дунд, том татвар төлөгчийн асуудал хариуцсан татварын албаны татварын хяналт шалгалтын нэгжид шатлан дэвшүүлж томилно.

7.1.5. Татварын ерөнхий газарт харьяа татварын албанд 5-аас доошгүй жил ажилласан ёс зүй, сахилгын зөрчилгүй албан хаагчийг чадахуйн зарчмын дагуу Татварын ерөнхий газарт дэвшүүлэн томилно.

7.1.6. Татварын ерөнхий газрын мэдээллийн технологи, эрсдэл, татварын удирдлага, олон улсын татварын чиглэлээр ажиллуулахад 7.1.5 дахь заалт хамаарахгүй.

Найм. Татварын улсын байцаагчийн эрх олгох, эрхийг хасах,  
хүчингүй болгох, түтгэлзүүлэх

8.1. Татварын ерөнхий газрын дарга Татварын ерөнхий хуулийн 77.7.4-т заасан бүрэн эрхийн дагуу дараах шаардлага хангасан албан хаагчид татварын улсын байцаагчийн эрх олгоно.

8.1.1. Төрийн албаны /салбар/ зөвлөлийн тогтоолоор нэр дэвшиж, санал болгосон албан хаагч /хураагч, хүний нөөц, нягтлан бодогч, дотоод ажилтан/-ийг чиглүүлэх сургалтад хамрагдаж төгссөн сертификатыг үндэслэлэх; -

8.1.2. Татварын улсын байцаагчийн эрх олгогдоогүй төрийн жинхэнэ албан тушаалд томилогдон ажиллаж байгаа албан хаагчийн туршилтын хугацаандаа чиглүүлэх сургалтад хамрагдаж төгссөн сертификатыг үндэслэлэх.

8.2. Татварын ерөнхий газрын дарга татварын улсын байцаагчийн эрхийг хасах, хүчингүй болгох, түдгэлзүүлэх асуудлыг дараах үндэслэлээр шийдвэрлэнэ.

8.2.1. Татварын улсын байцаагчийг холбогдох хууль тогтоомжийн дагуу ажлаас халсан шийдвэр гарсан тохиолдолд татварын улсын байцаагчийн эрхийг хассанд тооцно;

8.2.2. Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлд заасан үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөгдсөн бол түүний татварын улсын байцаагчийн эрхийг хүчингүй болгоно.

8.2.3. Татварын улсын байцаагчийг жирэмсний болон хүүхэд асрах чөлөөтэй, байгууллагын захиалгаар сургалтад хамрагдсан тохиолдолд төрийн албанаас түр чөлөөлсөн тушаалаар түүний татварын улсын байцаагчийн эрхийг түдгэлзүүлсэнд, эгүүлэн томилсон тушаалаар татварын улсын байцаагчийн эрхийг сэргээсэнд тооцно;

8.2.4. Хууль хяналтын байгууллагын шийдвэрийг үндэслэн Татварын ерөнхий газрын даргын тушаалаар түдгэлзүүлэх, хасах, хүчингүй болгох арга хэмжээ авч болно.

8.3. Сангийн сайдын тушаалаар баталсан "Татварын улсын байцаагчид үр дүнгийн шагнал олгох журам"-д заасны дагуу Татварын ерөнхий газрын даргын шийдвэрээр татварын улсын байцаагчийн эрх олгогдсон татварын улсын байцаагчид сар бүр үр дүнгийн шагналт цалинг олгоно.

Ёс. Хариуцлага

9.1. Энэ журмын 4.1.1, 4.1.2, 4.1.3-д заасан шаардлага хангахгүй иргэнийг томилсон албан тушаалтны шийдвэрийг Татварын ерөнхий газрын дарга хүчингүй болгож, буруутай албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцно.

9.2. Татварын улсын байцаагчийн эрх олгоогүй болон сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй албан хаагчид сар бүрийн үр дүнгийн шагнал олгохгүй

бөгөөд энэхүү журмыг зөрчин олгосон бол уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар төлүүлнэ.

Арав. Хэрэгжилт

10.1. Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын төрийн захиргааны удирдлагын хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж болон харьяа татварын алба нь журмын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, үйл ажиллагаандаа мөрдэж ажиллана.

---оОо---